210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
2105	Нормативт зардал	69,500,600.00	34,785,360.00	65,457,100.00	54,095,853.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,468,000.00	11,892,500.00	24,276,600.00	15,546,526.00
210502	Хоол, хүнс	52,504,800.00	18,903,860.00	34,652,700.00	33,120,227.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,527,800.00	3,989,000.00	6,527,800.00	5,429,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,811,300.00	3,330,100.00	7,851,400.00	6,251,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,118,200.00	1,118,200.00	1,118,200.00	-
210602	Тавилга	481,200.00	-		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,211,900.00	2,211,900.00	481,800.00	-
210604	Урсгал засвар			6,251,400.00	6,251,400.00
2107	Томилолт, зочны зардал	8,735,700.00	4,265,800.00	6,175,600.00	6,540,349.00
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт	8,735,700.00	4,265,800.00	6,175,600.00	6,540,349.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,759,000.00	13,634,281.50	7,391,200.00	6,540,349.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,531,800.00	4,810,571.00	3,824,700.00	3,824,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	651,400.00	587,100.00	2,299,300.00	2,089,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	539,100.00	70,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	245,117.50	295,700.00	281,820.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,600.00	88,600.00	14,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,403,400.00	7,125,093.00	203,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	188,300.00	188,300.00	188,300.00	141,129.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,700.00	50,400.00	45,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			450,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,938,800.00	26,239,539.00	24,905,600.00	20,493,841.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,056,600.00	20,427,339.00	11,489,200.00	7,077,441.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,882,200.00	5,812,200.00	13,416,400.00	13,416,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,671,900.00	27,120,300.00	32,756,300.00	31,476,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,671,900.00	27,120,300.00	32,756,300.00	31,476,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,293,000.00	2,741,400.00	5,994,300.00	5,374,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,878,900.00	23,878,900.00	25,602,000.00	25,602,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	1,160,000.00	500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	58,563,900.00	26,300,000.00	76,509,500.00	37,266,299.20
2200	Дотоод эх үүсвэрээр	58,563,900.00	26,300,000.00	76,509,500.00	37,266,299.20
223001	Бусад хөрөнгө	58,563,900.00	26,300,000.00	76,509,500.00	37,266,299.20
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000,000.00	13,200,000.00	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл	120,000,000.00	13,200,000.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,786,450,900.00	1,616,975,913.91	1,697,410,700.00	1,649,055,336.64

**Алдархаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	918,385,700.00	860,940,538.15	915,333,000.00	906,209,301.13
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	918,385,700.00	860,940,538.15	915,333,000.00	906,209,301.13
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	688,413,000.00	740,709,965.76	752,925,500.00	738,616,845.51
122005	Орон нутгийн төсвөөс	639,849,100.00	692,153,601.76	676,416,000.00	662,107,348.51
132004	Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/				
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	48,563,900.00	48,556,364.00	76,509,500.00	76,509,497.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,152,200.00	12,897,410.00	29,152,200.00	4,229,190.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих				
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,152,200.00	12,897,410.00	29,152,200.00	4,229,190.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	150,500,000.00	2,428,000.00	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	108,723,400.00	2,428,000.00		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	41,776,600.00			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,948,150.20	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	32,761,443.20	-	262,520.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	29.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	84.00	84.00	84.00	84.00
620001	Удирдах ажилтан	14.00	14.00	14.00	14.00
620002	Гүйцэтгэх ажилтан	54.00	56.00	54.00	57.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	14.00	16.00	13.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	166.00	163.00	166.00	166.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	86.00	83.00	86.00	86.00
630001	Төрийн өмчит ЕБС	86.00	83.00	86.00	86.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	80.00	80.00	80.00	80.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	80.00	80.00	80.00	80.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	84.00	84.00	84.00	84.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	10.00	10.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	-		34.00	34.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	34.00	34.00		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5.00	5.00	5.00	5.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00	19.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	7.00	7.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00	9.00	9.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,614,990.00	197,245,868.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,614,990.00	197,245,868.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,334,182.00	147,666,608.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	27,685,666.38

Алдархаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210101	Үндсэн цалин		27,685,666.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	26,180.00
210201	Тэтгэврийн даатгал	-	26,180.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	233,000.00
210301	Гэрэл, цахилгаан		233,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,769,988.00	7,175,440.00
210401	Бичиг хэрэг	228,168.00	547,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,409,320.00	6,472,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	132,500.00	137,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		17,600.00
2105	Нормативт зардал	15,797,985.00	56,175,986.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,726,189.00	46,871,836.00
210502	Хоол, хүнс	71,796.00	9,304,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,281,144.00	6,988,597.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,081,144.00	6,988,597.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,485,065.00	49,381,739.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,485,065.00	44,745,639.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,636,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,280,808.00	49,579,260.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,280,808.00	49,579,260.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,280,808.00	19,579,260.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	30,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,955,421.00	1,700,103.64
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,955,421.00	1,700,103.64
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,532,911.00	199,874,900.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,532,911.00	199,874,900.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,587,328.00	174,313,643.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,945,583.00	25,561,257.00

IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		928,928.62
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,500.00	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		928,928.62

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Чулуунбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан, төр засгийн бодлого үйл ажиллагаатай нийцсэн, орон нутгийн онцлог нөөц чадавхыг бүрэн дайчилсан, судалгаанд суурилсан эдийн засаг нийгмийн бодлогыг хэрэгжүүлж, хүмүүнлэг ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн, төрийн үйлчилгээг хүн амд ил тод шуурхай хүртээмжтэй хүргэж, улс аймгийн хэмжээнд тэргүүлэх түвшинд хүргэхэд оршино” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлэх;
- Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлэх;
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын Засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Дотоод хяналтын нэгж нь ТШЗ-ийн үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 2,719.37 сая төгрөгөөс 1.5 хувь буюу 40.79 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 30.59 сая төгрөгөөр тус тус тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 327.56 сая төгрөг болж өмнөх оноос 192.7 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 1.8 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 38.3 сая төгрөг нь СХС-ийн, 71.5 сая төгрөг нь ОНХС-ийн, 215.96 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага

Авлагын дансны үлдэгдэл 315.87 сая төгрөг болж өмнөх оноос 93.7 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь СХС-ийн авлага 10.07 сая төгрөгөөр өссөн ба Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвд үүссэн авлага байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Засаг даргын тамгын газар	0.00	26,794.06
Эрүүл мэндийн төв	229,124.00	84,603,400.00
Хүүхдийн цэцэрлэг	776,949.06	0.00
Сум хөгжүүлэх сан	221,171,700.00	231,244,791.00

Нийт дүн	222,177,773.06	315,874,985.06
----------	-----------------------	-----------------------

Илрүүлэлт: ТШЗ-ийн аудитаар Эрүүл мэндийн төвд үүссэн авлагыг Корона вирусээр хэвтэн эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний норматив, төсөвт өртгийн тооцоолол үндэслэлгүй байна гэж үзэн 31.88 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 179.91 сая төгрөг болж өмнөх оноос 37.75 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Эрүүл мэндийн төвд ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,618.06 сая төгрөг болж өмнөх оноос 838.71 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар автомашин, барилга, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ЗДТГ, ЕБС хооронд барилгыг балансаас баланст шилжүүлсэн зэрэгтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр

Өглөгийн дансны үлдэгдэл 73.21 сая төгрөг болж өмнөх оноос 41.33 сая төгрөгөөр өссөн байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.00	6,245,005.44
Засаг даргын тамгын газар	2,006,264.05	5,584,192.53
Хүүхдийн цэцэрлэг	254,990.00	0.00
Эрүүл мэндийн төв	5,643,701.79	43,682,383.93
ЕБ-ын сургууль	8,256,016.00	17,704,780.58
Соёлын төв	15,726,488.99	0.00
ДҮН	31,887,460.83	73,216,362.48

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 4,368.20 сая төгрөг болж өмнөх оноос 1,121.53 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 1,477.81 сая төгрөгөөр тоцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 219.60 сая төгрөгөөр нэмж, 1,697.41 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,697.41 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,620.91 сая төгрөгийг урсгал зардалд, 76.50 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 0.00 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 915.35 сая төгрөгийг улсын төсвөөс, 676.41 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 29.15 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 76.50 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 0.00 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 0.00 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 906.20 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 662.10 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4.22 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 76.50 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 38.00 сая төгрөг, нийт 1,687.02 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 10.39 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 38.00 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 38.00 сая төгрөгөөр давсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,609.15 сая төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 14.30 сая төгрөгийг сумын төсөвт, 4.72 сая төгрөгийг аймгийн төсөвт, 0.00 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.00 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 174.31 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 25.56 сая төгрөгийн, нийт 199.87 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 198.94 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.93 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс, 125 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 3 мэдээллийг огт мэдээлээгүй, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Алдархаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалт бүхий зөвлөмж өгөгдөж, биелэлт нь 80.6 хувьтай хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар нийт 266.99 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 257.38 сая төгрөгийн алдааг залруулж, 9.61 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ нэгтгэсэн санхүүгийн тайланг 257.38 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Шагналын зардал гаргасан, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, зардлыг зориулалт бус зарцуулж ажилчдад хувцас худалдан авч өгсөн зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.6. /хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх/, Засгийн Газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.13.7 /энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд/, 8 дугаар зүйлийн 8.4 /Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана/ гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдээдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн Аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ИТХ	2	6.90	-	0.00	-	0.00	-	0.00	2	6.90
2	ЗДТГ	14	415.64	4	141.85	1	3.49	6	11.76	3	258.54
3	Эрүүл мэндийн төв	9	632.16	4	36.86	2	31.89	1	556.87	2	6.54
4	ЕБС	7	117.90	2	30.89	1	2.03	-	0.00	4	84.98
5	Хүүхдийн цэцэрлэг	9	111.57	3	1.02	-	0.00	2	0.00	4	110.55
6	Соёлын төв	5	81.22	2	2.53	-	0.00	-	0.00	3	78.69
7	Төвлөрүүлэн захирагч	2	266.99	1	257.38	-	0.00	-	0.00	1	9.61
Дүн		48	1,632.38	16	470.53	4	37.41	9	568.63	19	555.81

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

ХЯНАСАН:

Г.ЧУЛУУНБААТАР

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

2022.03.25